



НЭГ. ХӨВСГӨЛ АЙМГИЙН 2017 ОНД ЭРҮҮ, ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА

2018 оны 01 сарын 09



1.1. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ

1.1.1. Хүлээн авч шалгасан нийт гомдол мэдээлэл

2017 онд Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газарт иргэн, аж ахуй нэгж байгууллагуудаас гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт 3461 гомдол мэдээлэл хүлээн авч шалгасан.

Үүнээс - 1526 буюу 44.1 хувь нь **гэмт хэргийн**

- 1935 буюу 55.9 хувь нь **зөрчлийн** талаарх гомдол мэдээлэл байна.

1.1.2. Гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг шийдвэрлэсэн байдал

Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 870-д нь эрүүгийн хэрэг үүсгэж, 696 гомдолд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан саналыг аймгийн прокурорын газарт хүргүүлсэн байна.



Гомдол мэдээллийг өмнөх онтой харьцуулсан байдал.




2016 он


2017 он

■ гэмт хэрэг

■ захиргааны зөрчил



2016 он




2017 он



■ Эрүүгийн хэрэг үүсгэсэн

■ Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан






1.2. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

➤ 1.2.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

- 2017 онд 870 үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсанаас гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр 121 *о́у́дуй* хэрэгсэхгүй болж статистик мэдээгээр нийт 749 гэмт хэрэг бүртгэгдсэн.
- 2017 оны байдлаар Хөвсгөл аймгийн хэмжээнд гэмт хэргийн гаралтыг урьд оны мөн үетэй харьцуулахад 42 хэргээр буюу 5.9 хувиар өссөн байна






1.3. Гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр

Бүртгэгдсэн нийт 870 хэргийн

- 441 гэмт хэрэг нь аймгийн төвд
- 423 гэмт хэрэг нь сумдад
- 6 гэмт хэрэг нь бусад аймагт бүртгэгдсэн.

Аймгийн төвд болон сумдад үйлдэгдсэн гэмт хэргийг урьд оны мөн үетэй харьцуулахад :






1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн төрлөөр





Үеэäýääñýí ãýìò õýðãèéã өнгөөр авч үзвэл хүний амь бие эрүүл мэндийн эсрэг 276 хэрэг буюу нийт хэргийн 36.8 хувь. Үүний дотор хүнийг санаатай алах гэмт хэрэг 8 буюу нийт хэргийн 1.06 хувь, бусдын бие мах бодид гэмтэл учруулах гэмт хэрэг 250 буюу нийт хэргийн 33.4 хувь, Хүний амь насыг болгоомжгүй байдлаар хохироох гэмт хэрэг / 94.1, / 1 буюу нийт хэргийн 0.1 хувийг, амиа хорлох золгүй учрал /95.1/ хэрэг 15 буюу нийт хэргийн 2.3 хувийг эзэлж байна.






Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 359 буюу 48.0 хувь үүний дотор бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 164 хэрэг буюу нийт хэргийн 21.9 хувийг, мал хулгайлах гэмт хэрэг 71 буюу нийт хэргийн 9.5 хувийг, авто тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг 63 буюу 8.4 хувийг, Дээрэмдэх гэмт хэрэг 18 буюу нийт хэргийн 2.4 хувийг, залилан мэхлэх гэмт хэрэг 21 хэрэг буюу нийт хэргийн 2.8 хувийг, Гээгдэл эд зүйл, алдуул мал ашигласан гэмт хэрэг 5 буюу нийт хэргийн 0.6 хувийг тус тус эзэлж байна.





Хүүхэд гэр бүл ёс суртахууны эсрэг гэмт 24 буюу нийт хэргийн 3.2 хувь. Үүний дотор хүчиндэх гэмт хэрэг 18 буюу нийт хэргийн 2.4 хувийг, гэр бүлийн хүчирхийлэлийн 6 хэрэг буюу 0.8 хувийг тус тус эзэлж байна.


■ 2016 он ■ 2017 он





Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 7 буюу нийт хэргийн 0.9 хувийг эзэлж байна. Үүний дотор танхайрах гэмт хэрэг 3 буюу нийт хэргийн 0,4 хувийг, галт зэвсэг хууль бусаар авч явах гэмт хэрэг 1 буюу нийт хэргийн 0.1 хувийг, галын аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчих гэмт хэрэг 3 буюу нийт хэргийн 0.4 хувийг эзэлж байна. Энэ төрлийн гэмт хэргийг урьд оны мөн үетэй харьцуулахад 9 хэргээр буюу 56.3 хувиар буурсан.


■ 2016 ■ 2017






Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг 17 буюу нийт хэргийн 2.3 хувийг эзэлж байна. Үүний дотор ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэрэг 3 буюу нийт хэргийн 0.4 хувийг, ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэрэг 14 буюу нийт хэргийн 2.3 хувийг тус тус эзэлж байна. Энэ төрлийн гэмт хэргийг урьд оны мөн үетэй харьцуулахад 8 хэргээр буюу 88.9 хувиар өссөн.

- Ан агнуурын хууль тогтоомж зөрчих /203/
- Ойн тухай хууль тогтоомж зөрчих /211/






ТХХАБАЖЭ гэмт хэрэг 46 бүртгэгдэж нийт хэргийн 6.1 хувийг тус тус эзэлж байна. Үүний дотор ТХХАББАЖ зөрчих гэмт хэрэг 42 буюу нийт хэргийн 5.6 хувийг, Ослын газар орхиж зугатаах гэмт хэрэг 3 буюу нийт хэргийн 0.4 хувийг, согтуу хүнд, бусдад жолоо шилжүүлэх гэмт хэрэг 1 буюу нийт хэргийн 0.1 хувийг эзэлж байна. Энэ төрлийн гэмт хэргийг урьд оны мөн үетэй харьцуулахад 4 хэргээр буюу 9.5 хувиар өссөн.






Хөвсгөл аймгийн сумдад үйлдэгдсэн гэмт хэргийн тоо





ГЭМТ ХЭРЭГ ӨССӨН СУМ


■ 2016 ■ 2017






Гэмт хэрэг буурсан сумд

■ 2016 ■ 2017






Мөрөн сумын багуудад үйлдэгдсэн гэмт хэргийн тоо





Гэмт хэрэг өссөн баг


■ 2016 ■ 2017





ГЭМТ ХЭРЭГ БУУРСАН БАГ

■ 2016 ■ 2017





Өссөн гэмт хэрэг

2017 онд аймгийн хэмжээнд нийт 749 гэмт хэрэг бүртгэгдэж урьд оны мөн үетэй харьцуулахад 42 хэргээр буюу 5.3 хувиар өссөн байна.


- Өнгөрсөн оны мөн үеэс Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 29 буюу 11.7 хувиар Үүний дотор Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг 12 хэргээр буюу 5.0 хувиар, хүний амь насыг санаатай хохироосон гэмт хэрэг 4 хэргээр буюу 100 хувь.
- Хүчиндэх 12 хэргээр буюу 2 дахин
- Гэр бүлийн хүчирхийлэл 2 хэргээр буюу 2 дахин
- Мал хулгайлах 7 хэргээр буюу 10.9 хувиар
- Дээрэмдэх гэмт хэрэг 14 хэргээр буюу 3 дахин
- Залилан мэхлэх гэмт хэрэг 2 хэргээр буюу 1.3 дахин



- Бусдын эд хөрөнгийг завших 1 хэргээр буюу 14.3 хувь
- Галын аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчих гэмт хэрэг 3 хэргээр буюу 3 дахин
- Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 14 буюу 4.6 дахин
- Ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэрэг 8 хэргээр буюу 88.9 хувиар
- ТХХАБАЖ /авто зам/ эсрэг гэмт хэрэг хэргээр буюу 9.5 хувиар тус тус өссөн



Өссөн гэмт хэрэг






Буурсан гэмт хэрэг

- ▶ Хүний эрх эрх чөлөө алдар хүнд нэр төрийн эсрэг гэмт хэрэг 1 хэргээр буюу 100 буурсан
- ▶ Булш ухах хэрэг 2 хэргээр буюу 2 дахин буурсан
- ▶ Асран хамгаалах үүргээ урвуулах 1 хэргээр буюу 100 хувь
- ▶ Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 6 хэргээр буюу 1.6 хувиар буурсан үүний дотор иргэний өмч хулгайлах гэмт хэрэг 16 хэргээр буюу 8.9 хувиар, тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг 5 хэргээр буюу 7.4 хувиар
- ▶ Гээгдэл эд зүйл, алдуул мал ашигласан гэмт хэрэг 15 хэргээр буюу 75.0 хувь
- ▶ Бусдын эд хөрөнгийг санаатай устгах, гэмтээх, хайнга хандах 2 хэргээр буюу 25.0
- ▶ Танхайрах 13 хэргээр буюу 81.3 хувиар
- ▶ Ан агнуурын хууль тогтоомж зөрчих гэмт хэрэг 1 хэргээр буюу 25.0 хувиар
- ▶ Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг 5 хэргээр буюу 71.5 хувь
- ▶ Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг 1 хэргээр буюу 25.0 хувиар тус тус буурсан



Буурсан гэмт хэрэг

■ 2017 ■ 2016





1.5. Гэмт хэрэг үйлдэгдсэн газар


- Нийт хэргээс гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 180 бүртгэгдэж урьд оны мөн үетэй харьцуулахад 4 хэргээр буюу 2.3 хувиар өссөн
- Гэр орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг 264 бүртгэгдэж урьд оны мөн үетэй харьцуулахад 2 хэргээр буюу 0.8 хувиар өссөн.
- Авто замд үйлдэгдсэн гэмт хэрэг 43 бүртгэгдэж урьд оны мөн үетэй харьцуулахад 8 хэргээр буюу 22.9 хувиар өссөн
- Аж ахуй нэгж байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг 14 бүртгэгдэж урьд оны мөн үетэй харьцуулахад 1 хэргээр буюу 7.7 хувиар өссөн
- Төрийн бус байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг 9 бүртгэгдэж урьд оны мөн үетэй харьцуулахад 5 хэргээр буюу .2 дахин өссөн байна.
- Төрийн байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг 9 бүртгэгдэж, хэргийг урьд оны мөн үетэй харьцуулахад 2 хэргээр буюу 18.2 хувиар буурсан байна.



1.6. ГЭМТ ХЭРГИЙН ИЛРҮҮЛЭЛТ

1.6.1. Гэмт хэргийн илрүүлэлт:


- 2017 онд бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцогдвол зохих этгээд тогтоогдоогүй хэрэг 536 үйлдэгдэж өмнөх оноос 100 хэргээр буюу 22.9 хувиар өссөн. Эдгээр хэргүүдээс 252 хэргийг илрүүлж хэргийн илрүүлэлт 47.0 хувьтай. Хэргийн илрүүлэлтийг урд оны мөн үетэй харьцуулахад 39.9 хувиар буурсан байна.






Согтуугаар болон бүлэглэж үйлдэгдсэг гэмт хэргийн харьцуулалт

■ Согтуу Хэрэг ■ Согтуу Хүн




2016




2017

■ Бүлэг Хэрэг ■ Бүлэг Хүн



2016



2017



ХОЁР.

ИРГЭДЭЭС АВСАН
СУДАЛГААНЫ ДҮН



- Дээрх байдлыг харгалзан үзэж гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байгаа Мөрөн сумын 9, 10, 13 дугаар багийн иргэдээс “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд таны өгөх санал” нэрийн доор солиологийн судалгааг явуулан нийт 49 өрхийн насанд хүрсэн 124 иргэнээс судалгааг бичгээр авч дүнг нэгтгэн боловсруулав. Үүнд.



- Та “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар ямар мэдээлэлтэй байдаг вэ” гэсэн асуултанд нийт иргэдийн
- 31,2 хувь нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар мэдэхгүй.
- 46 хувь нь энэ талаар сонсож байсан ч ийм ажилд оролцож байгаагүй.
- **22,8 хувьд нь энэ төрлийн ажлын талаар мэднэ, урьдчилан сэргийлэх ажилд оролцож байсан.**



- Таны оршин сууж байгаа газарт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил ямар хэмжээнд явагддаг вэ гэсэн асуултанд нийт иргэдийн
- **22,8 хувь нь хангалттай биш ч энэ талаар мэдээллийн хэрэгсэлээс мэдээлэл авдаг.**
- 39,4 хувь нь хэлж мэдэхгүй байна.
- 37.8 хувь нь огт мэдэхгүй гэж хариулсан.



- Цаашид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрхэн үр нөлөөтэй болгох вэ гэсэн асуултанд нийт иргэдийн
- **46,7 хувь нь улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр энэ талаараа ажил сайн явуулах.**
- **20 хувь нь Цахим мэдээллийн хэрэгсэлийг энэ үйл ажиллагаандаа сайн ашиглах. /facebook гэх мэт/**
- **19,6 хувь нь Цагдаагийн байгууллага өөрсдийн хийсэн ажил, илрүүлсэн хэргийнхээ талаар мэдээлэл өгдөг байх.**
- 13,7 хувь нь Хороо хариуцсан Цагдаагийн ажилтан нарыг хариуцсан газарт нь байнга ажиллуулах, энэ чиглэлийн ажлаа айл бүрт хүргэх зэрэг саналуудыг гаргасан байна.



ГУРАВ. ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГҮҮДИЙН ӨССӨН ШАЛТГААН



3.1. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн талаар

Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газарт 2017 онд 749 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 133 хэрэг согтуугаар үйлдэгдсэн байна.

Согтуугаар үйлдэгдсэн хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 71 хэрэг буюу 34,8 хувиар буурч, 146 хүн холбогдсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 42 хүнээр буюу 22,3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



үзүүлэлт	2016 он	2017 он	Өсөлт бууралт
Эрүүжлүүлэгдсэн хүн	1828	2051	+12,2%
эрэгтэй	1762	1990	92,4%
үүнээс эмэгтэй	66	61	-7,6%
Эрхэлсэн ажилгүй	1814	2003	+10,4%



хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөл, өлж буй хүчин зүйл



1. Баяр наадам,
хурим найр, төрсөн
өдөр тэмдэглэх гэх
мэт бусад зүйлээр
шалтаглан архидан
согтуурдаг,
согтууруулах
ундааг хэтрүүлэн
хэрэглэх

2. гэр бүлийн
гишүүдийн
хоорондын
таарамжгүй
харьцаа

3. Иргэдийн суурь
хүмүүжил
төлөвшил, ёс зүй

4. Амьжиргааны
түвшинтэй
холбоотой
бухимдал, гутран
ги үзэл бодол

5. Гэмт хэргийн
шалтгаан нөхцлийг
арилгах талаар олон
нийтийн байгууллага,
үйлдвэр албан газар,
хувийн хэвшлийн
байгууллагын
захиргаанаас авч явуулж
байгаа арга хэмжээ
хангалтгүй байгаа.

6. Зарим иргэдийн
ухамсар соёл
боловсролын
түвшин доогуур
байгаа байдал
нөлөөлж байна



3.2. Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн талаар

Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газар нь 2017 оны 01 сарын 01-ны өдрөөс 2018 оны 01 сарын 10-ны өдрийг хүртэл Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 17 бүртэгдсэн байгаа нь нийт хэргийн 2.3 хувийг эзэлж байна. Үүний дотор хууль бусаар ан агнах гэмт хэрэг 3 буюу нийт гэмт хэргийн 0.4 хувийг, ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэрэг 14 буюу нийт хэргийн 2.3 хувийг тус тус эзэлж байна



Энэ төрлийн гэмт хэргийг урьд оны мөн үетэй харьцуулахад 8 хэргээр буюу 88.9 хувиар өссөн байгаа ба иргэд Мөрөн суманд ойрхон байрлах сумдын нутаг дэвсгэрээс хууль бусаар мод бэлтгэн шөнийн цагаар аймгийн төв рүү оруулж ирж байна.

➔ 2017 онд энэ төрлийн гэмт хэргийн гаралт /Цагдаагийн байгууллагад бүртгэгдэх байдал/ ихссэн нь дараах хүчин зүйлүүдтэй холбоотой гэж үзэхээр байна.



➔ 2017 оны 07 сарын 01-ны өдрөөс эхлэх шинэчлэн батлагдсан Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиуд мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэгт хохирлын хэмжээ тооцохгүй байхаар хуульчилсантай холбоотой юм. Үүнээс шалтгаалаад Цагдаагийн байгууллагад эрхийн бичиггүй мод тээвэрлэсэн, хугацаа хэтэрсэн болон засварласан эрхийн бичгээр их бага хэмжээгээр мод тээвэрлэсэн бүх мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна.



- Энэ төрлийн гэмт хэргийн талаар иргэд гомдол гаргадаггүйгээрээ онцлогтой ба 2017 оны 11 сараас Нийтийн хэв журам хамгаалах тасгийн алба хаагчид шөнийн 01 цагаас өглөөний 07 цагийн хооронд шөнийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж, үүрэг гүйцэтгэх хугацаандаа энэ төрлийн гэмт хэргийг шуурхай илрүүлэх, жижүүрийн бүрэлдэхүүн тухай бүр нь хойшлуулашгүй ажиллагааг явуулж байгаатай холбоотой байна.



Иргэд шинэчлэн батлагдсан хууль тогтоомжуудын талаарх мэдээ мэдээллийг хангалттай хэмжээнд авахгүй, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хангалттай түвшинд байхгүй, дан ганц Цагдаагийн байгууллагаас гаргасан тоон мэдээ, урьдчилан сэргийлэх ажлыг бусад байгууллагууд ашиглаж байгаатай холбоотой байна



3.3. Насанд хүрээгүй хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд түүний шалтгаан нөхцөл

Насанд хүрээгүй хүүхдээс үйлдэгдсэн гэмт хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэмт хэрэг 5 буюу 17.9 хувиар буурсан, холбогдогч нь 8 буюу 25 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




Хүүхдээс үйлдсэн гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл:

- Хулгайлах гэмт хэрэгт -14
- Бусдын бие махбодид гэмтэл учруулах -2
- Хүчиндэх- 2
- Дээрэмдэх -2
- Бусдын эд зүйлийг санаатайгаар устгаж гэмтээх -2
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журмын зөрчил -2
- Нийт-24 хүүхэд гэмт хэрэгт холбогдсон байна. Эдгээр хүүхдүүдийн 3 нь оюутан, 15 нь сургуулийн сурагч байгааг өмнөх онтой харьцуулахад оюутнуудаас үйлдсэн хэрэг 75 хувиар, сурагчдаас үйлдсэн хэрэг 34,8 хувиар буурсан байна.



Нийгмийн байдлаар нь авч үзвэл






	Зүйл хэсэг	Насны байдал	Хүйс	Хүүхдийн тоо
1	Хүнийг алах - Хүнд,	9	эр	1
2	Хүнийг амьжиргалт хорлох нөхцөл байдалд хүргэх	16-17	Эр 2, эм 1	3
3	Хүний эрүүл мэндэд хангалуун хохирол учруулах	5-17	Эр 2, эм 1	4
4	Хүчиндэх	4, 12-17	Эм	9
5	Бусдын эд хөрөнгийг булаах	17	Эр 1, эм 1	2
6	Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх	13-15	эр	6
7	Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх	1	эр	1
8	Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохиж хамгаалалтгүй байлгах	5, 7, 9, 11-17	Эр 1, эм 4	5
9	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих /нас барсан/	3, 15-16	Эр 3, Эм 5	8
10	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих /гэмтэж бэртсэн/	9, 15,16	Эр 2, эм 1	3
11	Бусдын бие махбодид гэмтэл учруулах	12, 15, 16, 17	Эр 2, эм 2	4




Хүчиндэх гэмт хэргийн улмаас үйлдэгдсэн хэрэг 12 буюу 200 хувиар өссөн үзүүлэлттэй байна.






Үйлдэгдсэн газраар нь авч үзвэл





Шалтгаан нөхцөл






Хүүхдээс үйлдэж байгаа болон гэмт хэргийн улмаас хохирч байгаа шалтгаан нь:

- Эцэг эхийн хараа хяналтгүй байдал
- Эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгчдийн уялдаа холбоо муу байна.
- Гэр бүлийн насанд хүрсэн хүмүүс гэр бүл ахуйн хүрээндээ архи согтууруулах ундааны зүйл хэрэглэдэг байдал
- Гэр бүл дэх хүчирхийлэл, хэрүүл, маргаан таагүй харьцаа
- Хүүхдийн ухамсар, төлөвшил, хууль эрх зүйн мэдлэггүй, хүмүүжлийн доголдолтой байдал зэрэг нөлөөлж байна.



3.4. ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДЭЭД БАЙГАА ШАЛТГААН НӨХЦӨЛ






- Хөвсгөл аймгийн хэмжээнд үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 48.05 хувь буюу 359 нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг эзэлж байна. Үүнээс иргэдийн өмчийг хулгайлах гэмт хэрэг 299 үйлдэгдсэнээс:
- Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 164
- Мал хулгайлах 71 гэмт хэрэг буюу нийт хэргийн 9,5 хувь.
- Орон байранд нэвтэрч үйлдэгдсэн гэмт хэрэг 142 буюу 58,2 хувь.
- Авто тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг 63 буюу 8.9 хувь.
- Дээрэмдэх гэмт хэрэг 18 буюу нийт хэргийн 2,4 хувь.
- Залилан мэхлэх гэмт хэрэг 21 хэрэг буюу нийт хэргийн 2.8 хувь.
- Гээгдэл эд зүйл, алдуул мал ашигласан гэмт хэрэг 7 буюу нийт хэргийн 0.9 хувийг тус тус эзэлж байна.



Иргэдийн өмчийг хулгайлах нийт 299 гэмт хэргийн задаргаа





- Хулгайлах гэмт хэргийг үйлдэж байгаа этгээдүүдийн дийлэнх хувь нь 17-оос 37 хүртлэх идэр насны, ямар нэгэн орлогогүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, /малчин/ нэн ядуу, тэнэмэл амьдралтай гэх мэт амьдралын нөхцөл байдлаас шалтгаалсан байна.
- Энэ хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүний тухайд хувийн хүмүүжил, амьдарч буй орчин, эцэг эх хамт олны хараа хяналт сул байдал, найз нөхдийн нөлөөлөл, сургууль завсардалт, гэр бүлийн таагүй уур амьсгал, өсөж хүмүүжиж байгаа орчин гэр бүлийн хүчирхийлэлээс болж гэрээсээ дайжих асуудлаас болж бусдад уруу татагдах гэх мэтчилэн хүчин зүйлс нөлөөлж байна.



- Орон байранд нэвтэрч үйлдэгдсэн хулгайн хэргийн хохирогчийн сонор сэрэмж, эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт сул байдал ихээхэн нөлөөлж байна. Жишээлбэл: гэр, байшингаа ил цоожоор цоожлох, цонхны хамгаалалтгүй, гэрэлтүүлэг камергүй, дээврийн хөндийг цоож хаалгагүй орхих, олон хоногоор хүнгүй орхих зэрэг асуудлууд давамгайлжан нөлөөлж байна.
- Мөн хууль өөрчлөгдсөнтэй холбоотойгоор орон байранд нэвтэрч хулгай хийсэн тохиолдолд хохиролын хэмжээ шалтгаалахгүй шууд гэмт хэрэгт тооцогдох болсон.



- Орон байрны хулгайн гэмт хэрэг үйлдэгдэж байгаа цаг хугацаагаар нь авч үзвэл дийлэнх нь өдрийн цагаар буюу үдээс хойш 12 цагаас 18 цагийн хооронд иргэдийн ажлын цагаар, нийтийн арга баяр ёслол амралт зугаалагын үеэр үйлдэгдсэн байна.
- Алдагдсан эд зүйлийг эд зүйлсийг гэмт этгээдүүд зарж борлуулсан байдал:
- Мөрөн суманд сумдын хүн тээврийн товчоо, зах олны хөл хөдөлгөөнтэй газар
- Барьцаалан зээлдүүлэх газарт тавих, энэ төрлийн эд зүйлсийг худалдан авч дамалж зардаг иргэд
- Их хэмжээний эд зүйлсийг тус аймгаас өөр төв суурин газарт бусад аймагт аваачиж зарж борлуулах
- Бэлэн мөнгөтэй байдаг хүнс барааны дэлгүүр, үйлчилгээний газаруудад тус тус зарж борлуулдаг.



- Урьд оны мөн үетэй харьцуулхад тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг 10,8 хувиар өссөн тоон үзүүлэлтэй байна.
- Хөвсгөл аймагт үйлдэгдэж байгаа тээврийн хэрэгсэл хулгайлсан гэмт хэргийн 96,9 хувь нь гудамж талбай, нийтийн зогсоол, хашааны гадна орчин гэх зэрэг газраас хулгайд алдагдсан байдлаар үйлдэгджээ.
- Хулгайлсан тээврийн хэрэгсэлийн 64 нь буюу 96.9 хувь нь БНХАУ үйлдвэрлэгдсэн мотоцикль байна. Гол шалтгаан нь гудамжинд хашааны гадна орчинд мотоциклио эзэнгүй орхих явдалаас үүдэлтэй байдаг. Мөн ихэнх мотоцикль улсын бүртгэл дугаар номергүй байдаг ба энэ нь цаашид эрэн сурвалжлах, гэмт хэргийг илрүүлэх ажилд хүндрэл учируулдаг.



- Мал хулгайлах гэмт хэргийн 76,2 хувь нь бэлчээрт, мөн 73 хувь нь аймгийн төвтэй ойр сумдын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн. Тухайн хэрэг малын тарга тэвээрэг гүйцсэн үеэс буюу 08 сараас 12 сарын сүүлч хүртлэх хугацаанд ихээр үйлдэгддэг. Ихэнх тохиолдолд бэлчээрт хараа хяналтгүй байгаа бод малыг тээврийн хэрэгсэл ашиглан хулгайлж эзэнгүй өвөлжөө хаваржааны хашаанд нядалж, мах арьс шийрийг авч толгой шийрийг хэргийн газарт үлдээсэн байдаг. Мөн бод малыг амьдаар нь мал махны ченжүүдэд, махны үйлдвэрүүдэд зарж борлуулдаг.
- Хулгайд алдагдсан мал махыг мал нядалгааны газар мах борлуулж худалдан авдаг цэг, ченж, хувь хүмүүс худалдан авсан байдаг.



- Мал хулгайлах гэмт хэргийг үйлдэж байгаа этгээдүүдийн 72 хувийг 17-30 настай, 15 хувийг 30-35 насны, 10 хувийг 35-40 насны 5 хувийг 40 дээш настай хүмүүс эзлэж байна.
- Дээрх хүмүүсийн 74 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй, Мөрөн суманд сумдаас шилжин ирж түр оршин сууж байгаа иргэд байгаа ба 26 хувь нь мал бүхий малчин иргэд үйлдсэн байна. 2017 онд энэ хэрэгт эмэгтэй 1 хүн холбогдсон байна.
- Уг хэргийг үйлдэж байгаа этгээдүүд нь давтан үйлддэг. 2017 онд хуулийн тэгшитгэлээр энэ төрлийн гэмт хэрэг үйлдээд ял шийтгэгдэж байсан хүмүүс олноор суллагдаад дахин гэмт хэрэг үйлдэж байна.



3.5. Зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл, түүнийг шалгасан байдал

2017 онд Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газарт иргэн, аж ахуй нэгж байгууллагуудаас зөрчлийн шинжтэй 6472 гомдол мэдээлэл хүлээн авч шалгасан.

Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг шийдвэрлэсэн байдал:


6346 зөрчлийг 272,116,300 төгрөгөөр торгож ердийн журмаар шийдвэрлэсэн байна.

Зөрчлийн хэрэг үүсгэн шалгасан зөрчил:


126 зөрчилд зөрчлийн хэрэг үүсгэн шалгасан байна. Үүнээс хялбаршуулан шалгах журмаар шийдвэрлэсэн 12, торгож шийдвэрлэсэн 32, үүнээс цагдаагийн алба хаагч 25 зөрчлийг 4,450,000 төгрөгөөр, шүүгч 7 зөрчлийг 900,000 төгрөгөөр тус тус торгож, баривчилсан 89, эрх хассан 5 зөрчил байна.



Зөрчил үйлдэгдсэн газар




Зөрчлийн шийдвэрлэлт /Хуулийн зүйл хэсгээр/







Зөрчил гаргагчийн насны ангилал




АРХИДАН СОГТУУРСАН БУЮУ ТОДОРХОЙ ЗӨРЧЛИЙН УЛМААС ЭРҮҮЛЖҮҮЛЭГДСЭН, БАРИВЧЛАГДСАН ХҮНИЙ ТОО







**ДӨРӨВ:
ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД
ГАРГАХ САНАЛ, АВЧ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ.**




**4.1. ТӨРИЙН БОЛОН
ТӨРИЙН БУС
БАЙГУУЛЛАГА, ИРГЭД
ХООРОНДЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД.**




- Орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хөршийн холбоог гудамж болгонд бий болгож ахлагчийг томилон энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх яриа таниулга хийх, гэр орон сууцны цонх хаалганд хамгаалалт төмөр тор суулган цоож цуургыг ил харагдахгүй далд байдлаар хийлгэх, цаашлаад гэрэлтүүлэг камер, дохиололтой болгох зэрэг асуудлыг ухуулан таниулах, цаашлаад аймгий хэмжээний цогц бодлого болгон явуулах, төсөл хөтөлбөрийг аймгийн ГХУСЗЗ-тэй хамтран зохион байгуулах.



- 
- Иргэдэд үнэт зүйлсээ Цагдаагийн байгууллагад бүртгэлжүүлж судалгаанд хамруулах, их хэмжээний бэлэн мөнгө, үнэт зүйлсээ эзэнгүй үедээ гэр орондоо орхихгүй байх талаар яриа таниулга хийж зөвлөмж хүргүүлэх
 - Техник технологи өндөр хөгжиж байгаа өнөө үед хүний хөлийн болон доргилтоор асдаг дуут дохио, мэдрэгчтэй гэрэл зэрэг техник хэрэгсэлүүд зах зээл дээр хямдаар худалдаалагдаж байгаа тул айл өрх албан байгууллагууд энэ төрлийн багаж хэрэгсэлийг ашиглах.



- 
- Мотоцикль хулгайд алдагдах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардалгатай байна. Үүнд:
 - мотоциклийг улсын дугаартай болгон бүртгэлжүүлэх.
 - Мотоциклийн дугуй, жолооны гарыг түгждэг хамгаалалт мөн дохиололтой болгох.
 - Мотоциклио хашааны гадаа гудамжинд орхихгүй байх зэрэг асуудлыг хийж хэрэгжүүлэх хэрэгтэй.
 - Цагдаагийн байгууллагийн зүгээс дээрх нөхцөл бололцоо арга замыг иргэдэд сурталчлан таниулж ойлгуулах, энэ шаардлагийг хангасан мотоциклийг замын хөдөлгөөнд оролцуулах, эргүүл хяналтыг сайтар тавьж ажиллах.

Мал хулгайлах гэмт хэргийг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах ажил, арга
ХЭМЖЭЭ


- Малчдыг бод малаа байнгын хариулга манаатай болгох.
- Багуудад байгуулагдсан малчдын бүлэг нөхөрлөлийн үйл ажиллагааг шинэ шатанд гаргах, сургаж дадлагажуулах.
- Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллагуудыг өргөнөөр татан оролцуулах.

- 
- Бага насны хүүхдийг заавал насанд хүрсэн иргэнд хүлээлгэн өгөх. /тухайн хүүхдийн гэр бүлийн насанд хүрсэн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс бусад өөр хүн ирсэн тохиолдолд заавал тодруулж шалгасны эцэст хүүхдийг хүлээлгэн өгч байх.
 - Ар гэрийн шалтгаан, өвчний улмаас чөлөө авсан болон олон хоногоор хичээл тасалж буй хүүхдийн ар гэрээр нь эргэж тойрч шалтгаан нөхцөлийг тодруулдаг. Хүүхдийн биед ямар нэгэн байдлаар бэртэл гэмтэл байгаа эсэхийг нягталж шалгадаг байх.

- 
- 
- Мөрөн суманд ахуйн хэрэглээний газ үнэрлэсний улмаас 1 хүүхэд амь насаа алдсан. Сурагчдыг ахуйн хэрэглээний газ, цавуу /мансууруулах бодис/-ны хор хөнөөл, сөрөг үр нөлөөллийн талаар мэдээллээр хангах, сурагчдын үүргэвч, цүнх зэргийг гэнэтийн байдлаар шалгадаг байх. Эцэг эхчүүдэд энэ талаар мэдээлэл өгч хамтран ажиллах.
 - Хүүхэд нэг бүртээ тулж ажиллах. Насанд хүрээгүй хүүхдийн сэтгэл зүйн онцлог, гэр бүлийн таагүй байдал, хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй байдлыг урьдчилан мэдэж шаардлагатай арга хэмжээг авч холбогдох байгууллагад нь мэдээлэх.




4.2. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД.



➤ Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах талаар төрийн болон хэвшлийн байгууллагад бичиж буй мэдэгдлийн чанарыг сайжруулах, бичсэн мэдэгдлийн мөрөөр шалгах ажиллагааг тогтмол явуулж хариуцлага тооцож байх.


➤ Хөршийн холбоо болон олон нийтийн цагдаагийн ажилтнуудыг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллах.


➤ Холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран согтууруулах ундаагаар үйлчилгээ явуулдаг цэг салбаруудад улирал тутамж хяналт шалгалт хийж зөрчилтэй аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх.





■ Сургуулийн орчинд хүүхдийг гэмт хэрэг зөрчилд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “School police”-ийг чанаржуулж зөвхөн зам дээр зогсох биш, сургуулийн орчинд идэвхитэй ажиллуулах.

■ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд Өсвөрийн сэргийлэгч бүлгэмийн гишүүдийн нөөц бололцоог ашиглах.

- 
- Хууль бусаар мод бэлтгэх хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн газрын болон энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа албан байгууллагын алба хаагч нар хамтран нэгдсэн эргүүл шалгалтыг улирлын чанартай тогтмол хийх, энэ чиглэлээр ажиллаж байхдаа дан ганц гаргасан зөрчилд нь арга хэмжээ авах биш иргэдэд Шинэчлэн батлагдсан хууль тогтоомжуудын талаар танилцуулан, зөвлөгөө өгч ажиллах.


- 
- Цагдаагийн байгууллагаас болон бусад байгууллагаас хийж хэрэгжүүлж байгаа ажлыг нийтэд хүргэх чиглэлээр цахим мэдээллийн хэрэгсэлийг түлхүү ашиглах. Facebook, twitter орчинд давалгаа /challehg/ өрнүүлэх, төрийн байгууллагуудын цахим хаягаар мэдээллээ тогтмол нэвтрүүлэх.
 - Иргэдийг урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, тэдний мэдээллийг урамшуулах.

- 
- Орон байрны хулгайн гэмт хэргийг таслан зогсооход Цагдаагийн байгууллагын зүгээс хулгайн хэрэг их гараад байгаа цаг хугацаа, газар байршилд явган болон хөдөлгөөнт эргүүлийг явуулах чиглэлийн маршрут гаргаж ажиллах.
 - Мал хулгайлах гэмт хэрэг ихээр үйлдэгддэг газрууд болон тэр цаг хугацаанд байнгын болон түр хяналтын постууд, шөнийн эргүүлийг гарган ажиллуулах зэрэг болно.



**4.3. ХУУЛЬ ХЭРЭГЛЭХ БОЛОН,
ТӨР ЗАХИРГААНЫ ТҮВШИНД
АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД.**

- ▶ Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн “согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох” тухай 90 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах.
- ▶ Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг нь хохирлын хэмжээ шаардагдахгүй, гаргасан үйлдэл бүрт нь эрүүгийн хэрэг үүсгэхээр байгаа тул энэ талаар холбогдох хуулийн байгууллагад мэдээлэл хүргүүлж, бэлтгэсэн модны хэмжээ болон гаргасан үйлдлээс нь шалтгаалан эрүүгийн хэрэг үүсгэх, эсхүл зөрчлийн хуулиар арга хэмжээ авах эсэх асуудлыг шийдвэрлэдэг байхаар албан ёсны тайлбар, заавар зөвлөмж гаргуулах.



► Монгол улсын зөрчлийн тухай хуулинд зарим төрлийн харилцааг зохицуулалгүй орхигдуулсан байгаагаас иргэд хохирох, зөрчил үйлдсэн этгээд шийтгэлгүй үлдэх зэрэг асуудал гарч байна. Жишээлбэл:

► **Нэг:Зөрчлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйл /Танхайрах/**

1. Олон нийтийн газарт :


1.1 хэрүүл маргаан үүсгэж


1.2. бусдыг өдөөн хоргоож


1.3.бусдын амгалан тайван байдал алдагдуулж

1.4. олон нийтийг үл хүндэтгэж

1.5. үйлчилгээний болон дарааллын журам зөрчиж биеэ авч явах нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг зөрчсөн, эсхүл аж ахуй нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтанд хамруулж 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна гэж хуулинд заасан байгаа боловч **гэр орон сууцанд болон бусад газарт** танхайрах зөрчил үйлдсэн тохиолдолд ямар арга хэмжээ авах, ямар хариуцлага тооцохыг нарийвчлан заагаагүй байна.

- 
- Зөрчлийн тухай хуулинд гээгдэл буюу санамсаргүй олдсон эд зүйлийг завших, ашиглах, үрэгдүүлэх зөрчлийг оруулалгүй орхигдуулсан нь мөн иргэдийг хохироож байна. Энэ талаар Эрүүгийн хуулинд хохиролын хэмжээ 300,000 төгрөг хүрсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэхээр заасан байна.
 - Зөрчлийн тухай хуулинд “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих” заалтанд согтууруулах ундаагаар үйлчилдэг баар цэнгээний газрууд цагийн хуваарь хэтрүүлсэн, согтууруулах ундааны зүйлийг зориулалтын бус газарт хэрэглэсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх талаар заалтыг нарийн оруулаагүй орхигдуулсан байна.


- 
- Байнга архидан согтуурч зөрчил үйлддэг тухайлбал: гэр орондоо агсам согтуу тавьдаг гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг этгээдүүдийг сэтгэц наркологиын эмч болон төрийн бус байгууллагын ажилтнаар сургалт оруулах.
 - Хөршийн холбоог мэргэжлийн удирдлагаар ханган иргэд, олон нийтийн хүч туслалцааг авч ажиллах. Гудамж бүрийг хяналтын камертай гэрэлтүүлэгтэй болгох.
 - Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх ажлын зардлыг тогтоол гаргуулах, эргүүл шалгалтаар ажиллах тээврийн хэрэгсэл болон шатахууны асуудлыг шийдүүлэн төрийн болон төрийн бус байгууллагын ажилчин алба хаагч нарыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулж эргүүл шалгалт хийлгүүлэх.



Хяналт шалгалт явуулах эрх бүхий мэргэшсэн байгууллагууд үйл ажиллагаагаа харилцан хамааралтайгар явуулах, хамтран хяналт шалгалт хийх нь үр дүнтэй байгаа бөгөөд цаашид уламжлагдсан ирсэн үйл ажиллагаануудыг явуулахаас гадна хийж хэрэгжүүлж байгаа ажлаа цахим орчинг ашиглаж олон нийтэд сурталчилах ажлыг шинэ түвшинд гаргах хэрэгцээ шаардлага тулгарч байна.



- Цагдаагийн байгууллагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой үйл ажиллагааг явуулж байгаа хэдий ч энэ нь төдийлөн иргэдэд хүрэхгүй байгаа нь иргэдээс авсан судалгаагаар харагдаж байна.
- Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа телевизийн сувгууд нь ЛХА, ТОД, ДДШ-ийн хүлээн авагчуудаар цацагдаж байгаа ба дийлэнх өрхийн хэргэлдэг ДДШ-ийн энгийн багцад аймгийн хэмжээний телевизийн сувгууд гардаггүй, нэмэлт төлбөр төлсөн тохиолдолд сувгууд нээгддэгээс шалтгаалаад Хөвсгөл аймгийн иргэд Цагдаагийн байгууллагаас явуулж байгаа мэдээллийг цаг тухай үед нь хүлээн авч чадахгүй байна.



Иймд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зөвхөн аймгийн хэмжээний телевизүүдэд яриа өгөх, нээлттэй хаалганы өдөрлөг хийхээр хязгаарлахгүйгээр энэ үйл ажиллагаандаа цахим мэдээллийн хэрэгсэлийг түлхүү ашиглах шаардлагатай байна.

Facebook, twitter орчинд давалгаа /challehg/ өрнүүлэх, төрийн байгууллагуудын цахим хаягаар мэдээллээ тогтмол нийтэлж, нийтлүүлсэн мэдээллийг share хийж дамжуулан түгээснээр цаг хугацаа хэмнэх, санхүүгийн зардал багатайгаар шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.



➤ АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

